



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор  
2025 оны 02 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер: М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Н.Батчимэг  
Утас: 91113253 Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/39

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020250

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 хөтөлбөрийн 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилт 98.6 хувьтай байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ





ಮಹತ್ವದ ನಿರೀಕ್ಷೆಗಳು, ರಾಜ್ಯ

2024.08.08

ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ

ಬೆಂಗಳೂರು, 8 ಅಕ್ಟೋಬರ್ 2024  
ಶ್ರೀಮತಿ. **ಪ್ರತಿ** ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

ಪ್ರತಿ ಸರ್ಕಾರಿ ಅಧಿಕಾರಿಗಳಿಗೆ,  
ರಾಜ್ಯದ ಆರೋಗ್ಯ ಮತ್ತು ಕುಟುಂಬ ಕಲ್ಯಾಣ ಇಲಾಖೆ,  
ಬೆಂಗಳೂರು.

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,752,202,147.00</b>	<b>4,260,362,819.00</b>
33	<b>АВЛАГА</b>	2,752,202,147.00	4,260,362,819.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	134,283,521.00	-
335	<b>Бусад авлага</b>	2,617,918,626.00	4,260,362,819.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,617,918,626.00	4,260,362,819.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,752,202,147.00</b>	<b>4,260,362,819.00</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>5,940,000.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	5,940,000.00
413	<b>Өглөг</b>	-	5,940,000.00
4136	<b>Бусад өглөг</b>	-	5,940,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,940,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,752,202,147.00</b>	<b>4,254,422,819.00</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,752,202,147.00	4,254,422,819.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,752,202,147.00	4,254,422,819.00
51210	Өмнөх үеийн үр дүн	2,752,202,147.00	2,752,202,147.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,502,220,672.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,752,202,147.00</b>	<b>4,260,362,819.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,360,372,500.00</b>	<b>3,318,532,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,900,000.00</b>	<b>39,072,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	31,900,000.00	39,072,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,900,000.00	39,072,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,900,000.00	39,072,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,328,472,500.00</b>	<b>3,279,460,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,328,472,500.00	3,279,460,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,328,472,500.00	3,279,460,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,664,707,409.00</b>	<b>1,816,311,328.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,664,707,409.00</b>	<b>1,816,311,328.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	64,999,900.00	111,935,505.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	64,999,900.00	111,935,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,999,900.00	111,935,505.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,599,707,509.00	1,704,375,823.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,012,459,079.00	831,226,880.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,012,459,079.00	831,226,880.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	587,248,430.00	873,148,943.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	587,248,430.00	873,148,943.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>695,665,091.00</u>	<u>1,502,220,672.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>695,665,091.00</u>	<u>1,502,220,672.00</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>2,366,497,500.00</u>	<u>3,458,755,521.00</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	38,025,000.00	179,295,521.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	38,025,000.00	179,295,521.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	31,900,000.00	173,355,521.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,900,000.00	39,072,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		134,283,521.00
120009	Бусад орлого	6,125,000.00	5,940,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<u>2,328,472,500.00</u>	<u>3,279,460,000.00</u>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,328,472,500.00	3,279,460,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,328,472,500.00	3,279,460,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>2,928,235,930.00</u>	<u>4,060,311,328.00</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,928,235,930.00	4,060,311,328.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	64,999,900.00	111,935,505.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	64,999,900.00	111,935,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,999,900.00	111,935,505.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<u>2,863,236,030.00</u>	<u>3,948,375,823.00</u>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,141,704,079.00	3,075,226,880.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,141,704,079.00	3,075,226,880.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	721,531,951.00	873,148,943.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	721,531,951.00	873,148,943.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<u>(561,738,430.00)</u>	<u>(601,555,807.00)</u>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	561,738,430.00	601,555,807.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	561,738,430.00	601,555,807.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<u>561,738,430.00</u>	<u>601,555,807.00</u>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,752,202,147.00	0.00	2,752,202,147.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,752,202,147.00	0.00	2,752,202,147.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,752,202,147.00	0.00	2,752,202,147.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,752,202,147.00	0.00	2,752,202,147.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,752,202,147.00	0.00	2,752,202,147.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,502,220,672.00	0.00	1,502,220,672.00
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,254,422,819.00	0.00	4,254,422,819.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,279,460,000.00	3,187,162,385.00	92,297,615.00	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,279,460,000.00	3,187,162,385.00	92,297,615.00	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,250,000.00	111,935,505.00	314,495.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,250,000.00	111,935,505.00	314,495.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,250,000.00	111,935,505.00	314,495.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,167,210,000.00	3,075,226,880.00	91,983,120.00	97.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,167,210,000.00	3,075,226,880.00	91,983,120.00	97.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,167,210,000.00	3,075,226,880.00	91,983,120.00	97.1

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг хэрэгжүүлэх” зорилготой, нийгмийн халамжийн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхийн зэрэгцээ Хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлого шийдвэртэй уялдуулж “Халамжаас хөдөлмөрт” гэсэн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 332 иргэд 2,244,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг ХХҮГ-ын дарга Э.Энхтөр, 2 дугаар гарын үсгийг ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Алтанцэцэг нар зурж, нярвын үүргийг ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх, ажилд зуучлал хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Сайханжаргал гүйцэтгэсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг ХХҮЕГ-ын Хяналт шалгалт дотоод аудит мониторингийн хэлтэс хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 4,260,362.8 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 1,508,160.7 мянган төгрөгөөр буюу 54.8 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт** (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,752,202.1	4,260,362.8	1,508,160.7
Авлага	2,752,202.1	4,260,362.8	1,508,160.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,752,202.1</b>	<b>4,260,362.8</b>	<b>1,508,160.7</b>
Өр төлбөр	0.0	5,940.0	5,940.0
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	2,752,202.1	4,254,422.8	1,502,220.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,752,202.1</b>	<b>4,260,362.8</b>	<b>1,508,160.7</b>

Эх сурвалж: ХЭДС-ийн 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь авлагын данс байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөртэй холбоотой авлагын үзүүлэлт**

(мянган төгрөгөөр)

д/д	Төсөл	Авлагын эхний үлдэгдэл	Тайлант онд олгосон санхүүгийн дэмжлэг	Төлсөн авлагын дүн	Авлагын эцсийн үлдэгдэл
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1,312,850.1	500,000.0	226,707.9	1,586,142.2
2	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	107,030.1	-	9,217.8	97,812.3
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	696,637.3	1,360,000.0	190,840.5	1,865,796.8
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	215,459.8	64,000.0	54,257.1	225,202.6
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэгжүүлэх хөтөлбөр	280,618.0	320,000.0	117,856.0	482,762.0
6	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, гарааны биенесийг дэмжих хөтөлбөр	5,323.4	-	2,676.5	2,646.9
	<b>ДҮН</b>	<b>2,617,918.7</b>	<b>2,244,000.0</b>	<b>601,555.8</b>	<b>4,260,362.8</b>

Эх сурвалж: ХЭДС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, харилцах дансны хуулга, мөнгөн хөрөнгийн журнал

Оны эхний хөтөлбөртэй холбоотой авлагын үлдэгдэл 2,617,918.7 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 601,555.8 мянган төгрөгийн авлага төлөгдөн тайлант онд шинээр нэмж олгосон 2,244,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн авлага нэмэгдсэн байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 29 иргэн хамрагдаж 128,000.0 мянган төгрөгийн зээл авч

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
гэрээний дагуу 50 хувийг буцаан төлөхөөр гэрээ хийж, авлагаар 64,000.0 мянган төгрөгийг бүртгэжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,940.0 мянган төгрөг байгаа нь данс андуурч орсон гүйлгээг буцаан шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,502,220.7 мянган төгрөгөөр өсөж 4,254,422.8 мянган төгрөг болсон байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2024 оны төсвийн төслийг боловсруулан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 10,000.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын санхүүжилтийг 4,405,475.0 мянга нийт 4,415,475.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 4,415,475.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 2 удаа тодотгон 985,231.5 мянган төгрөгөөр бууруулан ХХҮЕГ-ын даргын 2024.11.19-ний өдрийн “ХЭДС-ийн 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” А/386 дугаар тушаалаар өмнөх оны үлдэгдэл 134,283.5 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 16,500.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын санхүүжилтийг 3,279,460.0 мянга нийт 3,430,243.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 3,430,243.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72102 (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих) хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгосон 3,430,243.5 мянган төгрөгийн батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,187,162.4 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь үндсэн зардлыг 92,297.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой 2023-2024 онд хэрэгжүүлсэн “Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл”-д Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуйн нэгж хамрагдаж 36 иргэнийг ажлын байраар хангаж 159,192.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Тайлант онд 873,148.9 мянган төгрөгийн орлогыг ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	ХӨДӨЛМӨР НИЙТЛЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ	49,250.0	48,546.4	703.6	98.6

**Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1.1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	29,600.0	29,596.4	3.6	100.0
1.2	Ажилд зуучлах үйлчилгээ	19,650.0	18,950.0	700.0	96.4
2	<b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>	<b>3,117,960.0</b>	<b>3,026,680.5</b>	<b>91,279.5</b>	<b>97.1</b>
2.1	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	100,830.0	93,819.1	7,010.9	93.0
2.2	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	2,328,400.0	2,301,149.4	27,250.6	98.8
2.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	149,730.0	144,722.0	5,008.0	96.7
2.4	Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ	320,040.0	319,848.0	192.0	99.9
2.5	Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төсөл	218,960.0	167,142.0	51,818.0	76.3
3	<b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>112,250.0</b>	<b>111,935.5</b>	<b>314.5</b>	<b>99.7</b>
3.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	112,250.0	111,935.5	314.5	99.7
<b>ДҮН</b>		<b>3,279,460.0</b>	<b>3,187,162.4</b>	<b>92,297.6</b>	<b>97.2</b>

*Эх сурвалж: ХЭДС-ийн 2024 оны төсвийн тохируулгын дэлгэрэнгүй тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 3,279,460.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 3,279,460.0 мянган төгрөгөөс 6.0 хувиар буюу 196,767.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 157,414.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст холбогдох мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг ХХҮГ-ын даргын 2024.06.07-ны өдрийн 506 тоот албан бичгээр Төрийн аудитын байгууллагад хариуг ирүүлж хэрэгжилтийг FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ХЭДС-аас 2020 оноос өмнөх хамтран зээлдэгчгүйгээр олгосон нас барсан 17 иргэний 95,386.6 мянган төгрөгийн зээл төлөгдөөгүй байгаа ба ХХҮЕГ-т жил бүр судалгааг хүргүүлдэг боловч ямар нэгэн шийдэр гаргаагүй байгаа асуудлын анхаарах шаардлагатай.

2. “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд ХЭДС-аас 2021 онд 130,000.0 мянган төгрөгийг иргэдэд санхүүгийн дэмжлэгт олгосон бөгөөд орон нутгийн төсвөөс 2022-2024 онд төлөж барагдуулах хуваарьтай байсан ба 2023, 2024 оны төлбөр 85,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төлж барагдуулаагүй тул ТЕЗ-ийн аудитаар авч үзэх шаардлагатай

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 140,165.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 140,165.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 140,165.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 157,414.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 17,249.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 5.2 Албан шаардлага

5.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд ХЭДС-аас худалдан авсан бичиг хэрэг, шатахуун зэрэг нярвын тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: ХЭДС-аас 2024 онд худалдан авсан бараа материалын тайланг нөхөн гаргах, цаашид бараа материалын тайланг гаргаж хэвших, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

5.2.2. ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд олгосон 9 иргэний 53,600.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2021 онд олгосон 14 иргэний 21,950.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний 2021 онд олгосон 8 иргэний 7,865.0 мянга, 2022 онд олгосон 15 иргэний 56,750.0 мянга, нийт 46 иргэний 140,165.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9 дэх “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 29.9.2 дахь “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих”, ХХҮГын иргэнтэй байгуулсан гэрээ, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн зээлийн 140,165.0 мянган төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ авч хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд ХЭДС-аас худалдан авсан бичиг хэрэг, шатахуун зэрэг нярвын тайлан гаргаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд олгосон 9 иргэний 53,600.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2021 онд олгосон 14 иргэний 21,950.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний 2021 онд олгосон 8 иргэний 7,865.0 мянга, 2022 онд олгосон 15 иргэний 56,750.0 мянга, нийт 46 иргэний 140,165.0 мянган төгрөгийн хугацаа хэтэсэн зээлийг барагдуулаагүй байна.	1	140,165.0	-	-	1	140,165.0	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>140,165.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>140,165.0</b>	<b>-</b>	<b>-</b>

-----oOo-----